



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2014 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Өргөдлийн байнгын хорооны 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

Хэлэлцсэн нь:

Иргэн О.Эрдэнэцэцэгээс “Төрийн өмчийн сургуульд 28 жил ажилласан хэдий ч 2013 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход хувийн сургуульд ажиллаж байсан гэсэн шалтгаанаар Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4-т заасан мөнгөн тэтгэмжийг авч чадахгүй байгаа тул хуулийн хэрэгжилтийг хянан шалгах” асуудлаар, иргэн Г.Цогбадрахаас “өөрийн эхнэр нь Боловсролын тухай хуулийн 43.1.4-т заасны дагуу төрийн өмчийн сургуульд 25-аас дээш жил ажилласан боловч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө хорт хавдрын өвчний улмаас нас барж, хуульд заасан мөнгөн тэтгэмжийг авч чадаагүй тул хуулийн 43.1.4-т “өндөр насны тэтгэвэр тогтоохоос өмнө өвчний улмаас нас барсан тохиолдолд мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох” агуулга бүхий нэмэлт, өөрчлөлт оруулах” асуудлаар, иргэн Д.Дамдинсүрэн, ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний Эвлэлийн Нэгдсэн Хорооны дарга С.Дэлгэрмаа нараас “Боловсролын тухай хуулийн 43.1.4-т заасан мөнгөн тэтгэмжийг “бүх шатны сургууль”-д ажилласан иргэнд олгодог байсныг 2012 оны 10 дугаар сарын 26-нд Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг”-т ажилласан иргэн гэж зааснаараа их, дээд сургуульд ажилласан иргэд мөнгөн тэтгэмж авах боломжгүй болсон тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж их, дээд сургуулийг хамруулах” асуудлаар тус тус ирүүлсэн өргөдлүүдийг хэлэлцсэн тухай

Шийдвэрлэсэн нь:

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалтад заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн...”-д олгохоор заасан. Гэтэл харьяа яамнаас иргэнд “өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо төрийн болон орон нутгийн өмчийн сургуульд ажиллаж байсан байх” буюу хуульд заагдаагүй шаардлагыг тавьж байгаа нь Боловсролын тухай хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэхгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт, 43.3 дахь хэсэг хоорондоо агуулгын хувьд зөрчилтэй байгаагаас гадна дээрх мөнгөн тэтгэмжийг олгох буюу мөнгөн тэтгэмжийн хэмжээг хэрхэн тогтоох, тэтгэмж авах шаардлагыг хангасан хэдий ч өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо хувийн өмчийн сургуульд ажиллаж байсан тохиолдолд төсөвт хэрхэн тусгах зэрэг асуудал тодорхой биш байна гэж үзэв.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах талаар Засгийн газар /Н.Алтанхуяг/-т дараах чиглэлийг өгөх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1/Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллан иргэдийг хохиролгүй болгох;

2/Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт, 43.3 дахь хэсгийн хоорондын зөрчлийг арилгах, 43.1.4 дэх заалтад их, дээд сургуульд ажилласан иргэнийг хамруулах, уг шаардлагыг хангасан боловч тэтгэврийн насанд хүрэхээсээ өмнө нас барсан иргэн, түүний гэр бүлийн гишүүнд дээрх мөнгөн тэтгэмжийг олгох боломжтой эсэх талаар судлан, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу 6 сарын дотор холбогдох арга хэмжээг авч, тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

БАЙНГЫН ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Р.БУРМАА

Х.БАТТӨГСӨХ